



УВС АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

УВС АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ САРЫН ТАНИЛЦУУЛГА */ тойм /*


2014/02




ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2014 ОНЫ 2 ДУГААР САРД

1. 329 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрсөн хүүхдийн тоо 1 –ээр буюу 0.3 хувиар өссөн байна.


Хүн амын нас баралт 76 гарч өнгөрсөн оны мөн үеэс 2.7 хувиар өссөн бөгөөд 1000 хүнд 1.03 ноогдох болсон нь ноднингийн мөн үеэс 0.03 промилээр өндөр байна.




Нэг хүртэлх насандаа 3 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеэс 3 хүүхдээр цөөн буюу 50.0 хувиар буурч, 1 – 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл гараагүй байна. 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын эндэгдлийн түвшин 9.1 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 9.2 промилээр буурсан байна. Өмнөх 4 жилийн дунджаас нялхсын эндэгдлийн түвшин 17.5, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 24.5 промилээр тус тус буурсан байна.



2. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 64 болж өнгөрсөн оны мөн үеэс 19.0 хувиар буюу 15 гаралтаар буурсан байна. Эхний 2 сард гарсан халдварт өвчний тоо өмнөх 4 жилийн 2 сард гарсан халдварт өвчний дунджаас 46.7 хувиар бага байна.




Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнийг хувиар авч үзвэл гепатит өвчин өмнөх оны мөн үед нийт халдварт өвчний 29.1 хувийг эзэлж байсан бол 2014 оны 2 сарын байдлаар 16.6 пунктээр буурч салхинцэцэг 6.2 пунктээр, БЗХӨ 14.5 пунктээр тус тус өссөн байна.



4. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1599 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 60.2 хувиар буюу 601 хүнээр өссөн байна. Аймгийн хэмжээнд 820 эмэгтэй ажил идэвхитэй эрж байгаа нь ажилгүйчүүдийн 51.3 хувийг эзэлж байна.


Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо, сүүлийн 5 жилээр



5. 2014 оны 1200 ажлын байр шинээр бий болгох зорилттойгоос 15 шинэ ажлын байр бий болж зорилтын биелэлт 1.3 хувиар биелүүлсэн байна.


6. НДС-д шимтгэлээр 2.0 тэрбум төгрөг оруулахаас 1.7 тэрбум төгрөг оруулж төлөвлөгөөг 14.7 хувиар төлөвлөгөөг тасалсан байна. 2013 оны эхний 2 сартай харьцуулахад НДШ-ийн орлого 153.1 сая төгрөгөөр буюу 9.8 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого, тэрбум төгрөг




7. Нийгмийн халамжийн сангаас 2014 оны 2-р сард 11.6 мянган хүнд 1.1 тэрбум төгрөг зарцуулжээ.

Халамжийн сангийн зарцуулалт, сая төгрөг



8. Оны эхний 2 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 61 болж өнгөрсөн оны мөн үеэс 32.6 хувиар, өмнөх 4 жилийн дунджаас 1 гэмт хэргээр буюу 2.0 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн гаралт жилээр, тоо




Гэмт хэргийн өнгөөр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 66.7 хувиар буурч, хүний амь эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 16.7 хувиар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2.3, нийгмийн аюулгүй эсрэг гэмт хэрэг 1.5 дахин өсчээ.


Гэмт хэргийн 26.2 хувь нь согтуугаар, 9.8 хувь нь бүлэглэж үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 15.8 хувиар буурч, бүлэглэж үйлдэгдсэн гэмт хэрэг 1.5 дахин өссөн байна.

9. Шүүхээр 27 гэмт хэрэгт 36 хүн ял шийтгүүлснээс таслуулсан гэмт хэргийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 92.9 хувиар өсч, шийтгүүлсэн хүний тоо 12.2 хувиар буурсан байна. Шүүхээр таслуулсан гэмт хэргийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 25.6 хувиар өсч, шийтгүүлсэн хүний тоо 10.0 хувиар буурсан байна


10. Энэ оны 2-р сарын 15-28 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индекс өнгөрсөн оны мөн үеэс 8.6, оны эхнээс 1.7, суурь оноос 36.9 хувиар өсч, өмнөх сарын түвшинд байна.



Дээрхи өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ тарифын индекс оны эхнээс 2010 оны 2 сард 5.9, 2011 оны 2 сард 4.1, 2012 оны 2 сард 4.2, 2013 оны 2 сард 1.9 хувиар өссөн ба 2014 оны 2 сард эдгээр онуудаас 0.2-4.2 пунктээр бага байна.



11. Оны эхний малын 0.1 хувь буюу 1.7 мянган толгой мал хорогдсон нь өнгөрсөн оныхоос 6 дахин буюу 8.5 мянган толгойгоор бага байна.



12. Арилжаалагдаж байгаа бүх малын үнэ өнгөрсөн оны мөн үеэс 0.4 – 69.4 хувиар өссөн байна. Үүний дотор эр хонины үнэ 69.4, гүүний үнэ 40.9, эр ба эм борлоны үнэ 40.7, үнээний үнэ 40.6, эр ба эм төлөгний үнэ 28.8, хурганы үнэ 24.5, морины үнэ 11.7, эр ямааны үнэ 14.5, үнээний үнэ 6.3, эм хонины үнэ 1.5, эм ямааны үнэ 0.4 хувиар өсчээ.

13. Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор оны эхний 2 сард аймгийн төсөвт 3,1 тэрбум төгрөг оруулахаас 3,2 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 103,3 хувьтай, 103,2 сая төгрөгөөр давж биелэгдлээ.

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 1,1 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 1,0 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 97,2 хувиар биелүүлж 2,8 хувиар буюу 31,2 сая төгрөгөөр тасарсан байна.

Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 419.4 сая төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 285.0 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 68.0 хувиар биелүүлж 32.0 хувиар буюу 134.4 сая төгрөгөөр тасарсан байна.





Аймгийн төсөвт өөрийн орлогоор 701.1 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 804.3 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 114.7 хувиар биелүүлж 14.7 хувиар буюу 103.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

14. Улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас ААНБ-ын орлогын албан татварын төлөвлөгөө 68 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татварынх 22.1 хувиар тасарч байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас үл хөдлөх хөрөнгө, бууны татварын орлогын төлөвлөгөө 6.8 хувиар, авто болон өөрөө явагч хэрэгслэлийн татварын орлогынх 38.8, хог хаягдлын үйлчилгээний хураамж 76.9, хүү торгуулийн орлого 66.7, хөрөнгө борлуулсны орлого 73.4 хувиар тус тус тасарсан байна.


15. Төсөвт байгууллагууд 82.0 сая төгрөгийн өртэй, 84.4 сая төгрөгийн авлагатай гарч, өмнөх оны мөн үеэс өглөг 44.8 сая төгрөгөөр буурч, авлага 21.1 сая төгрөгөөр өслөө.



16. Аж үйлдвэрийн салбар энэ оны эхний 2 сард 2005 оны зэрэгцүүлэх үнээр 752,3 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 35.6 хувиар буюу 197.7 сая төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

/сая.төг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр/



Оны үнээр 1.3 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 25.9 хувиар, борлуулалт 10.4 хувиар өссөн байна.

Аж ахуйн нэгжүүд 37 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гол нэр төрлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч, 10 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч, өнгөрсөн оны мөн үед үйлдвэрлэгдэж байгаагүй 3 нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлдвэрлэж байсан 6 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдээгүй байна. Чацарганы тос 7.7, чацарганы шүүс 6.2, жимсний варень 5.4, сандал 4.1, гэрийн модон тавилга 2.2, тараг 2.2, хиам 2.2, гоймон 2.0 дахин, нүүрс олборлолт 98.1, чацарганы сироп 71.4, дээл 94.3, морин хуур 87.5, гурил үйлдвэрлэл 82.2, өлөн гэдэс боловсруулалт 71.3, нарийн боов 13.4, дулаан түгээлт 21.5, цэвэр ус түгээлт 9.1 хувиар тус тус өсч, хэрчсэн гурил 90.9, пальто үйлдвэрлэл 85.0, бялуу 64.3, талх үйлдвэрлэл 41.2, напелон торт 37.5, шевро 33.3, хивэг 27.9, арвайн гурилын үйлдвэрлэл 25.0, гутал 18.3 хувиар буурч булигар, хөх шир, даршилсан ногоо, өнгөрсөн оны түвшинд байна.

17. Банкны зээлийн өрийн үлдэгдэл 133.2 тэрбум төгрөгт хүрч, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 549.4 сая төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 49.6 тэрбум төгрөгөөр буюу 59.4 хувиар, хугацаа хэтэрсэн зээл 348.7 сая төгрөгөөр буюу 2.7 дахин өссөн байна.

137.2 сая төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.1 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 6.3 сая төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна.


Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл өмнөх 3 жилийн дунджаас 73.1 тэрбум төгрөгөөр буюу 2.2 дахин өссөн байна.



18. Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 50.7 тэрбум төгрөг болж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 10.4 хувиар буюу 4.8 тэрбум төгрөгөөр өсчээ. Сүүлийн 4 жилийн дунджаас иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 21.7 тэрбум төгрөгөөр буюу 75.0 хувиар өссөн байна.



19. Нийт импорт 3902.2 мян.ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2715.2 мян.ам доллароор буюу 40.0 хувиар буурсан байна.



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС